

СУРГАЛТАД НИЙГМИЙН СҮЛЖЭЭНИЙ САЙТЫГ ХЭРЭГЛЭХ БОЛОМЖ

Ч.Мягмаргармаа, Ц.Нямсүрэн, МУБИС

Abstract

Social Media tools are powerful drivers of change for teaching and learning practices, in terms of openness, interactivity and sociability. However, surveys about actual use that are carried out with large samples at a national level are still rare in our country. This study reports the results of a survey addressed to the MNUE's academic staff, with the aim of identifying the uses of Social Media in the field of university teaching practices. Analyses of data tested mostly affected frequency of use, and the relationships between motivations, ways of use, barriers to use and the scientific discipline. The results show that Social Media use is still rather limited and restricted and that academics are not much inclined to integrate these devices into their practices for several reasons, such as cultural resistance, pedagogical issues or institutional constraints. However, there are differences among academics in the ways they use Social Media or perceive them, mostly depending on the scientific discipline of teaching. Overall, the results emphasize ambivalent attitudes towards the benefits and challenges of Social Media in the context of higher education with obstacles prevailing over advantages.

Түлхүүр үг

Нийгмийн сүлжээний сайт, дээд боловсрол, сургалт, Сургалт Удирдлагын Систем (СУС)

Удиртгал

Нийгмийн сүлжээг web2.0-н санаа, технологи дээр суурилсан хэрэглэгчийн үүсгэсэн агуулга, мэдээлэл солилцох боломж бүхий интернетэд суурилсан программ гэж тодорхойлсон байна. Түүнчлэн нийгмийн сүлжээ нь байнга хувьсан өөрчлөгдөж байгаа энэ үед тогтсон тодорхойлолт өгөхөд төвөгтэй. Нийгмийн сүлжээний сайтууд, блог, вики, мультимедиа платформууд, виртуал тоглоомуудыг нийтэд нь social media гэж нэрлэж болохоор байна.

Сошиал медиа нь хэрэглэгчдэд агуулга үүсгэх, хуваалцах, хэлэлцэх өргөн боломжийг олгодог тул “динамик”, “интерактив”, “ардчилсан”, “хүн төвтэй”, “уян хатан”, “нийгмийн” болон “нийцтэй” гэжээ (Brown, 2012). Иймээс нийгмийн сүлжээ нь сургалтын үйл ажиллагааг илүү нийтийн, нээлттэй, хамтран ажиллахад чиглэсэн болгох боломжтой юм. Тухайлбал, нийгмийн сүлжээний сайтыг ашиглан олон нийтийн харилцаа дэмжлэгт тулгуурлан мэдлэг бүтээх, дамжуулах боломжтой (Dron & Anderson, 2014; Siemens & Weller, 2011). Академик сургалтад нийгмийн сүлжээг хэрэглэснээр сургалтын заах арга зүй, тухайлбал сурах сургах үйл ажиллагаа нэлээдгүй өөрчлөгдөнө.

Өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

Сүүлийн хэдэн арван жилийн турш мэдээллийн технологийн хөгжлийг дагаад МХХТ-н хэрэглээ салбар бүрд өсөн нэмэгдсээр

байна. Боловсролын салбарт МХТ-ийг хэрэглэх асуудал энэ цаг үетэй зэрэгцэн яригдаж эхэлсэн бөгөөд бүх түвшний багш нар сургалтдаа МХТ-ийг ашиглах болон зайн сургалтын системүүдээр цахим сургалт зохион байгуулж туршин, сайжруулсаар байгаа билээ. МУИС-ийн математикийн хичээлд МХТ-ийг ашиглах болон сургалт удирдах нээлттэй эхийн системүүд (Moodle, Wikispaces)-ээр цахим сургалтыг зохион байгуулж, сайжруулсаар байна (Навчаа, 2012. х.94).

Танхимын сургалтад лекц, семинарын хичээл дээр багш проектор, нөөтбүүк, ухаалаг утас ашиглан оюутнуудад хичээлийн агуулга, материалыг хүргэдэг. Танхимын бус цагаар оюутнуудад бие даан ажиллахад нь дэмжлэг болгох зорилгоор СУС (Сургалт Удирдлагын Систем) дээр математикийн хичээлийн онлайн талбар [анги]-г үүсгэсэн байх бөгөөд тэнд хичээлийн бүх материалууд, мультимедиа болон интерактив хэрэглэгдэхүүнүүдийг байршуулсан байна (Навчаа, 2017. х.100).

Суралцагчид онлайн хэлбэрээр бусад оюутантайгаа холбоотой, бие даалт, дасгал ажлыг орон зайнаас хамааралгүй хийснээр хичээлдээ илүү сонирхолтой болдог нь судалгаагаар нотлогдсон (Цэдэвсүрэн, 2016. х.105).

Судалгаанаас үзэхэд, тест болон хэлэлцүүлэгтэй, эргэх холбоо сайтай тул бусад

онлайн сургалтуудаас чанартай бөгөөд олон тооны MOOC (Massive Open Online Course) курсүүдийг нэгтгэн сан үүсгээд, бүх нийтийн боловсрол, насан туршийн боловсрол, албан бус сургалтуудад ашиглах нь зардал багатай, сургалт чанартай болох үр дүнтэй.

Харин их сургуулиудын сургалтын өнөөгийн нөхцөлд нэмэлт хичээл, багатгах хичээлүүдийг MOOC курс байдлаар бэлтгэж оюутнуудад хүргэвэл сурлагын чанарт сайнаар нөлөөлөх боломжтой (Мягмаргармаа, Нямсүрэн, 2014. х.122).

Монголын их дээд сургуулиудын хувьд СУС нь сургалтын үйл ажиллагаанд бэлэн болоогүй, оюутнууд байнга хэрэглэдэггүй зэрэг хүндрэлүүд байгаа учраас багш нар сургалтын үйл ажиллагаандаа нийгмийн сүлжээний сайтуудыг хэрэглэх шаардлагыг бий болгож, ингэснээр хичээл сургалтын үйл ажиллагаа нь илүү хүртээмжтэй болох боломжтой гэж үзэж байна.

Судалгааны арга зүй

Нийгмийн сүлжээний сайтууд (Twitter, Facebook), боловсролын сүлжээний сайтууд (Academia.edu г.м), блог болон вики (blogs, wikis), лекцийн материал байршуулах болон татаж авах боломжтой сайтууд (google drive г.м.), багаар ажиллах боломжтой сайтуудын (YouTube, Khan Academy, SlideShare) талаар, тэдгээрийг хэрэглэх давтамж, дур сонирхол, сургалтад хэрэглэж байгаа байдал, сул тал зэргийг тодруулах зорилгоор нээлттэй болон хаалттай асуулгын аргаар МУБИС, МУИС, МҮДС сургуулиудын нийт 30 багшаас судалгааг авч түүний үр дүнг нэгтгэж дүн шинжилгээ хийлээ. Ингэхдээ дараах 3 асуултад хариулт өгөхийг зорив. Үүнд:

- Сургалтын зорилгоор нийгмийн сүлжээг хэрхэн ашиглаж байгаа байдал
- Сургалтад нийгмийн сүлжээний сайтуудыг хэрэглэх боломжууд
- Нийгмийн сүлжээний сайтуудыг сургалтад хэрэглэхэд тулгарах бэрхшээл

Судалгааны үр дүн

Нийгмийн сүлжээний сайтуудыг сургалтын үйл ажиллагаандаа ямар сайтуудыг хэр давтамжтай хэрэглэдэг вэ? гэсэн асуултад дийлэнх хувь google багц, Slide share сайтуудыг ашигладаг гэж хариулжээ (Хүснэгт 1).

Хүснэгт 1

Сургалтын үйл ажиллагаанд хэрэглэх давтамж

Нийгмийн сүлжээний сайт	Өдөр бүр	7 хоногт	Сард	Хааяа
Twitter	0.5%	1%	1%	3%
Facebook	2.7%	5%	4%	7%
Google багц	4.5%	10%	12%	16%
Blog-Wiki	3.0%	8%	8%	10%
YouTube, Khan Academy	1.9%	8%	11%	18%
SlideShare	4.0%	13%	14%	18%

Нийгмийн сүлжээний сайтуудыг сургалтад хэрэглэхэд хэр үр дүнтэй/ ач холбогдолтой байдаг вэ? (Хүснэгт 2) гэсэн асуултад нийгмийн сүлжээний сайтуудыг сургалтад дараах 6 хэлбэрээр хэрэглэдэг нь ажиглагдлаа. Судалгааны үр дүнг давхардсан тоогоор хувилан харуулбал:

Хүснэгт 2

Нийгмийн сүлжээний сайтуудыг сургалтад хэрэглэх боломж

	Twitter	Facebook	Google drive	Blog- Wiki	YouTube, Khan Academy	Slide Share
Оюутны оролцоо, урам зоригийг нэмэгдүүлэх	25%	25%	16%	12%	25%	9%
Хамтын ажиллагаатай, оролцоотой суралцах боломжийг нээх	8%	20%	20%	22%	9%	14%
Оюутан хамгийн их ашигладаг хэрэгсэл дээр тулгуурлах	6%	22%	9%	6.8%	16%	7%
Сургалтын чанарыг сайжруулах	7%	18%	28%	20%	29%	27%
Шинэ хэрэгсэлтэй ажиллах, туршлага суух	8%	6%	12%	6%	9%	9%
Сургалтын материалыг оюутанд дамжуулахад хялбар байдал	7%	22%	35%	23%	29%	28%

Нийгмийн сүлжээний сайтуудыг суралцагчид хэрэглэж байгаа байдал, хандалтыг авч үзвэл сургалтын агуулгыг харахад youtube, санал сэтгэгдлээ илэрхийлэхэд facebook, суралцагчид материал илгээхдээ google багцыг ашигладаг болох нь дараах судалгааны үр дүнгээс харагдаж байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3

Суралцагчдын хандалт

	Агуулга харахын тулд	Санал, сэтгэгдэл оруулах	Файл илгээх, авах
Twitter	35%	26%	5%
Facebook	53%	30%	10%
Google багц	38%	19%	27%
Blog-Wiki	63%	26%	12%
YouTube, Khan Academy	81%	20%	7%
SlideShare	72%	12%	13%

Нийгмийн сүлжээний сайтуудыг сургалтад хэрэглэхэд тохиолддог бэрхшээл, сул талыг дурдана уу гэсэн нээлттэй асуултад ирсэн хариултуудыг нэгтгэн авч үзвэл:

- Сургуулийн сургалт удирдлагын системтэй ямар нэг холбоогүй
- Сургуулийн зүгээс үзүүлэх дэмжлэг дутуу
- Хувийн болон ажлын мэйл хаяг салангид байх шаардлагатай
- Хэрэглэх эсвэл суралцахын тулд их цаг зарцуулах шаардлагатай
- Үр дүнг нь хэмжих боломжгүй
- Багш суралцагчийн амьд харилцааг багасгадаг
- Багшийн хувьд их ачаалалтай
- Багш болон оюутны үндсэн үүргийг сулруулдаг
- Оюутнуудын анхаарал сарниулах хандлагатай
- Сургалтын материал зөвшөөрөлгүй бусдад тарах магадлалтай өндөр

Дүгнэлт

Энэхүү судалгаагаараа сургалтад нийгмийн сүлжээг хэрэглэж байгаа бодит байдал, сургалтад хэрэглэх боломж, сул талыг илрүүлэхийг зорив. Нийгмийн сүлжээний сайтууд нь сургалт удирдлагын систем биш боловч сургалтад үр дүнтэй ашиглах, тухайлбал, сургалттай холбоотой мэдээлэл хүргэх, мэдээлэлд

санал солилцох, мэтгэлцэх зэрэг боломжийг олгож байна.

Оюутны оролцоо, урам зоригийг нэмэгдүүлэхэд facebook, youtube, хамтын ажиллагаатай, оролцоотой суралцах боломжийг нээхэд google багц, оюутан хамгийн их ашигладаг хэрэгсэл дээр тулгуурлавал facebook, twitter, youtube, сургалтын чанарыг сайжруулах, суралцагчид судалгааны ажил хийх, бие даан нэмэлт материалууд уншиж судлахад slideshare, blog, wiki зэргийг ашиглавал тохиромжтой нь судалгааны үр дүнгээс харагдлаа. Тухайлбал, Facebook-г сургуулийн орчинд ашиглах боломжийг нь хязгаарласан байдаг тул танхимын сургалтад ашиглахад тохиромжгүй боловч суралцагчдын хандах давтамж өндөр учраас мэдээлэл түгээх, хичээлийн бус цагаар ашиглах бие даан ажиллах материалуудыг түгээхэд хамгийн их хэрэглээтэй, үр дүнтэй байдаг ажээ.

Google багцыг хэрэглэхэд хялбар, багаар ажиллах боломжтой зэрэг шинжүүдийг ашиглан сургалтын материалыг суралцагчдад дамжуулах, суралцагчдаас эргээд бие даан гүйцэтгэсэн материалуудыг нь хүлээн авах (google drive), багш суралцагчид хамтран нэг файл дээр ажиллах (google docs, sheets,...share), мэйлийн групп үүсгэх, мэдээлэл солилцох (google groups, gmail), судалгаа авах, суралцагчдыг үнэлэх (google form, superquiz, flubaroo ...) зэргээр сургалтад өргөнөөр хэрэглэж байна.

Эндээс үзэхэд, суралцагчдыг зохион байгуулах, зөвлөгөө өгөх, цахим хэлэлцүүлэг хийх зэрэг сургалтын “дээрээс доош” хандлагыг хэрэгжүүлэх, суралцагчдын сонирхлыг татах, тэднээс эргэх холбоо санал, сэтгэгдэл сонсох, суралцагчдаас гарсан бүтээлч санааг сургалтад хэрэглэх зэрэг “доороос дээш” хандлагыг хэрэгжүүлэхэд нийгмийн сүлжээг ашиглах боломжтой байна.

Нийгмийн сүлжээ нь мэдээлэлжсэн нийгэм дэх сургалтын чанарыг ахиулах, сургалтыг илүү хүртээмжтэй болгох нөөц/хэрэгсэл болж байна.

Ашигласан материал

- Brown, S. A. (2012). Seeing Web 2.0 in context: A study of academic perceptions. *The Internet and Higher Education*, 15, 1, 50-57.
- Dron, J., & Anderson, T. (2014). *Teaching Crowds. Learning and Social Media*. Edmonton: AU Press, Athabasca University.
- Facebook company statistics. Retrieved from <http://www.statisticbrain.com/facebook-statistics>
- List of virtual communities with more than 100 million active users. Retrieved from <https://>

- en.wikipedia.org/wiki/List_of_virtual_communities_with_more_than_100_million_active_user
- Siemens, G., & Weller, M. (2011). Higher education and the promises and perils of social network. Social networking Statistics. Retrieved from <http://www.statisticbrain.com/social-networking-statistics/>
- World internet usage and population statistics. Retrieved from <http://www.internetworldstats.com/stats.htm>
- Youtube company statistics. Retrieved from <http://www.statisticbrain.com/youtube-statistics/>
- Бат-Ирээдүй, Ж. (2011). Твиттер ба Монгол твиттерчид. Retrieved from <http://iregedui.blogspot.com/search/label/Твиттерийн%20тэмдэглэл>
- Боролзой, Д. (2015). Цахим хэвлэл, нийгмийн сүлжээний онцлог ба монгол хэл. Retrieved from https://www.academia.edu/23211165/цахим_хэвлэл_нийгмийн_сүлжээний_онцлог_ба_монгол_хэл
- Ганбаяр, Г., Нямсүрэн, Ц. (2016). Google API хэрэгслийг сургалтад хэрэглэж, туршсан нэгэн жишээ. Багшийн хөгжил, технологийн шинэчлэл, ОУЭШ Хурлын эмхэтгэл, 192-197.
- Ганбаяр, Г., Нямсүрэн, Ц. (2016). Суралцагчдын хичээлийн үнэлгээнд super quiz ашигласан нь (Мэдээлэл харилцааны технологи хичээлийн жишээн дээр), Боловсролын үнэлгээ ОУЭШ Хурлын эмхэтгэл, 500.
- Золзаяа, Б., Бадамсүрэн, Б. (2016). Нээлттэй эхийн видео хичээлийг сургалтад хэрэглэсэн туршилт, үр дүн. Багшийн хөгжил, технологийн шинэчлэл, ОУЭШ Хурлын эмхэтгэл, 145-153.
- Мягмаргармаа, Ч., Нямсүрэн, Ц. (2014). МООС хэрэгцээ, шаардлагын судалгаа. ШУА Информатикийн хүрээлэн, Эрдэм шинжилгээний бүтээл (14), 122-131
- Навчаа, Ц. (2012). Сургалт удирдах системийн туршилтын үр дүн. Математик, Компьютерийн ухаан - 2012, Retrieved from <https://www.geogebra.org/m/qgBmFu4s>
- Навчаа, Ц., Түмэнбаяр, Д. (2017). Оюутнуудын цахим сургалтад бэлэн байдлын шинжилгээ: МУИС-ийн эхний жилийн оюутнуудын жишээн дээр. Нээлттэй боловсрол 2017 Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 100-108.
- Норжинбуу, Б. (2015). Нийгмийн сүлжээ хэрэглэгчдийн өнөөгийн байдал. ММТ-2015
- Цэдэвсүрэн, Д., Нямсүрэн, Ц. (2016). Багш бэлтгэх сургалтад сургалтын нээлттэй цахим системийг туршсан нь. Нээлттэй боловсрол Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 105-111.